

## **МОНГОЛ УЛС: ЭКСПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

Байгаль орчин, нийгмийн менежментийн баримт бичиг

### **I. Удиртгал, ерөнхий мэдээлэл:**

Төслийн үйл ажиллагаа нь Монголын бүтээгдэхүүн экспортлогчид ялангуяа эрдэс баялагийн бус бүтээгдэхүүн экспортлогчдод төрөөс туслалцаа үзүүлэх замаар Монгол улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Төслийн агуулга нь “Экспортыг дэмжих хөтөлбөр”-т үндэслэгдэн Засгийн газрын санхүүгийн ба санхүүгийн бус дэмжлэгийн үйл ажиллагааг хамрана. “Экспортыг дэмжих хөтөлбөр” болон төслийн зорилго нь бүтээгдэхүүн экспортлодог болох эсвэл бүтээгдэхүүний экспортоо нэмэгдүүлж, өргөжүүлэхийг хүсч байгаа үндэсний үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлж, тэдний нөөц бололцоог нэмэгдүүлэх суурь бүтцийг бэхжүүлэхэд оршино. Ингэснээр Монгол улсын экспорт тэлж, экспортод гаргадаг бүтээгдэхүүний нэр төрөл олширч улмаар Монгол улсын олон улсын түвшинд өрсөлдөх чадвар нэмэгдэх болно.

Төслийг нэлээд өргөн хүрээг хамарсан цогц үйл ажиллагаа болгохыг зорьж байна. Төслийн хэтийн гол зорилго бол экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулахад чиглэх бөгөөд уг зорилгын хүрээнд төслөөр дэмжигдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн бүгдийг экспортлогчдод тэдгээрийн дотор гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн экспортлогчдод нээлттэй байлгана. Төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлэх экспортын тодорхой салбарууд ба/эсвэл экспортод гаргах бараа бүтээгдэхүүний ангилал нь Засгийн газрын бодлогын нэг хэсэг байх болно.

Төсөл нь экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг сайжруулах, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн зорилтоо хангах болно. Экспортод гаргах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг одоогийн экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөөс олшруулж, тэдгээрийн талаарх мэдээллийг экспортлогчдод шууд нээлттэй байлгах болно. Төслийн гол зорилт нь экспортлогчдод бараа бүтээгдэхүүний тээвэрлэхийн өмнөх үеийн зээл, нийлүүлэгчийн зээл, худалдан авагчийн зээл, төслүүд ба зөвлөх үйлчилгээний экспортын санхүүжилт, үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийн санхүүжилт, экспортын төслийн мөнгөн урсгал, экспортын даатгал ба баталгаа бүхий бүтээгдэхүүнүүд зэрэг боломжийн үнэ өртөгтэй экспорт-санхүүгийн хэрэгсэл (бүтээгдэхүүн, үйлчилгээ)-ийн жагсаалтаас сонгон авах боломж олгоход чиглэнэ.

Төслийн зүгээс экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглаж байгаа өнөөгийн байгууламжийг барих, өргөтгөх, шинэчлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг хийхэд оролцохгүй. Харин төсөл нь Монгол улсын Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компаниар шууд эсвэл арилжааны банкуудаар шууд бусаар дамжуулан экспортлогчдод экспортын үйлдвэрлэлийн байгууламжаа барих, засварлах эсвэл өргөжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын баталгаа гаргаж болох юм. Түүнчлэн Сангийн яам (СЯ) нь экспортлогчдод татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй тэнцэх хэмжээний тэтгэлэг \matching grants\ олгох бөгөөд тэтгэлэгийг хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд бус харин зөвхөн сургалт семинар, тээвэр гэх мэт үйл ажиллагаанд чиглэгдсэн хөрөнгө оруулалтад \soft investments\ зарцуулах болно.

### **II. Байгаль орчин, нийгмийн менежментийн баримт бичгийн тухай ерөнхий тойм**

Дэлхийн банкны Байгаль орчны үнэлгээ (Үйл ажиллагааны бодлого 4.01)-ний бодлогын дагуу төсөл нь байгаль орчны “FI” ангилалд орно. Үнэлгээний энэ ангилалд тодорхой дэд төслүүдийг Дэлхийн банкны санхүүжилтэнд хамруулж болох эсэхийг тогтооход санхүүгийн зуучлагч үүрэг бүхий төслүүд ордог.

СЯ, арилжааны банкууд, экспортлогчдын зүгээс холбогдох дүрэм журмыг хэрхэн дагаж мөрдөх талаар чиглэл өгөх зорилготойгоор Байгаль орчин, нийгмийн удирдлагын энэхүү зарчмыг Монгол Улсын хууль, дүрэм, журам (Хавсралт E-г харах), Дэлхийн банкны холбогдох хамгааллын бодлого (Хавсралт E-г харах)-той уялдуулан боловсруулаа. Хэрэв Монгол улс ба Дэлхийн банкны тавигдах

шаардлагын хооронд ялгаа гарах бол тэдгээрийн аль илүү чанга заалт бүхий шаардлагыг дагах ёстой (жишээ нь: дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээнд тавигдах шаардлагад Монгол улсын стандарт Дэлхийн банкны тавьдаг шаардлагаас илүү чанга бол Монгол улсын стандартыг мөрдөх эсвэл Дэлхийн банкны тавьдаг шаардлага, стандарт Монгол улсын холбогдох стандартаас илүү чанга бол Дэлхийн банкны стандартыг баримтална гэсэн үг юм). Хэрэв тавигдах хоёр шаардлагын хооронд зөрүүтэй байдал гарах бол СЯ асуудлыг шийдэхээр Дэлхийн банктэй зөвлөлдөнө.

Байгаль орчин, нийгмийн удирдлагын зарчмыг төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зааварт тусгасан байна.

Зарчим дараахи гол алхамуудаас бүрдэнэ. Үүнд:

#### **Дэд төслийн үнэлгээ:**

- Үндсэн шаардлагад нийцсэн байдал
- Ерөнхий үнэлгээ
- Хамгааллын баримт бичгүүд
- Олон нийтийн хэлэлцүүлэг ба мэдээллийг ил тод нээлттэй болгох үйл ажиллагаа
- Хяналт, баталгаажуулалт
- Хууль/гэрээгээр хүлээх үүрэг

#### **Дэд төслийн хэрэгжилт:**

- Мониторинг ба тайлагнах үйл явц

#### **Үндсэн шаардлагад нийцэх байдал:**

Төслийн санаанд тусгаснаар экспортлогчдыг санхүүгийн хэрэгсэл (бүтээгдэхүүн, үйлчилгээ)-ээр хангах, тэдэнд экспортын үйлдвэрлэлийн байгууламжаа барих эсвэл өргөтгөхөд нь хөрөнгө оруулалтын баталгаа гаргаж, Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани эсвэл арилжааны банкуудаар дамжуулан бодит хөрөнгө оруулалтыг зөвхөн шууд бусаар дэмжинэ. Байгаль орчин, нийгмийн удирдлагын зарчим нь бараа бүтээгдэхүүн экспортлогчдын өнөөгийн ба өнгөрсөн хугацаанд байгаль орчин, нийгмийн удирдлагаа хэрхэн гүйцэтгэж ирсэн байдалд чиглэхээс гадна хөрөнгө оруулалтын бус санхүүгийн арга хэрэгсэл хайж байгаа экспортлогчид, экспорттой холбоотой хөрөнгө оруулалт (тоног төхөөрөмж худалдан авах, үйлдвэрлэлийн байгууламжаа засаж шинэчлэх ба/эсвэл өргөтгөх)-нд баталгаа хайж байгаа экспортлогчдод чиглэх болно.

СЯ, арилжааны банкууд, Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани нь боломжит экспортлогчдын үндсэн шаардлагад нийцэж буй эсэхэд үнэлгээ хийх үүрэг хүлээнэ. Экспортлогчдын үндсэн шаардлага хангаж байгаа байдлыг тэдний үйлдвэрлэлийн дараах асуудлуудаар тогтооно.

#### **а. Хориглосон үйл ажиллагааны жагсаалт (Хүснэгт 1)**

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь доорхи хүснэгтийг ашиглан боломжит экспортлогчид үнэлгээ хийнэ. Хэрэв асуултаар тэдний өнөөгийн ба ирээдүйн экспортын үйл ажиллагаанд “тийм” гэсэн хариулт өгөгдсөн эсвэл тухайн хүснэгтийн жагсаалтанд орсон материалуудыг экспортлох ба импортлох боломжийг хайж байгаа гэж тогтоогдсон бол тухайн экспортлогч Дэлхийн банкны төслийн дэмжлэг авах боломжгүй байна. Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь Хүснэгтийг бөглөн төслийн баримт болгон хавсаргана.

**Хүснэгт 1: Хориглосон үйл ажиллагааны жагсаалт**

Шалгуур	Хамаарахгүй	Тийм	Үгүй
<p>Үйлдвэрлэгч нь дараахи үйл ажиллагааг эрхэлдэг ба явуулдаг эсэх?</p> <p>Цэрэг армийн ямар нэг зэвсэг;</p> <p>Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хүрээнд хориглодог ан амьтан, ургамлын худалдаа;</p> <p>Байгаль хүрээлэн буй орчинд генийн өөрчлөлтөнд орсон организмуудыг гаргах;</p> <p>Хориглосон пестицид, хербицидийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, худалдаа;</p> <p>Далай тэнгист тороор загас барих;</p> <p>Цацраг идэвхит бүтээгдэхүүнүүд;</p> <p>Аюултай хог хаягдлын хадгалалт, боловсруулалт, зайлуулалт;</p> <p>Хлорфторт нүүрстөрөгчид, галонс болон Монреалын протоколийн хүрээнд зохицуулагддаг бусад бодисууд агуулсан тоног төхөөрөмж, хэрэгслийн үйлдвэрлэл;</p> <p>Олон хлорт бифенилиудын үзүүлэх нөлөө 0.005 %-аас хэтэрсэн агууламж бүхий цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл;</p> <p>Шөрмөсөн чулуу агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;</p> <p>Цөмийн реакторууд, тэдгээрийн хэсгүүд;</p> <p>Тамхи (үйлдвэрлэлийн бус ба үйлдвэрлэлийн); Тамхины хатаасан навч боловсруулах машин;</p>			

**б. Үйл ажиллагааны зөвшөөрөл, байгаль орчны баталгаа, зөвшөөрөл, түсгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл (хүснэгт 2)**

*Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь боломжит экспортлогчийг үйл ажиллагааны холбогдох зөвшөөрлүүдээ шаардлагын дагуу авсан эсэх, тэдгээрийн хүчинтэй хугацаа, ойрын хугацаанд дуусах эсэхийг тогтоон холбогдох мэдээллийг цуглуулан хүснэгт 2-ийг бөглөнө. СЯ нь албан ёсны зөвшөөрлөө аваагүй ямар ч экспортлогчдод дэмжлэг үзүүлэхгүй. Харин тухайн экспортлогчийг шаардлагатай зөвшөөрлөө зохих ёсоор авч мэдээллээ тус яаманд ирүүлсэн үед дэмжлэг үзүүлэх боломжийг судлана.*

*СЯ тус Хүснэгтийг бөглөн төслийн баримтанд хавсаргана.*

## Хүснэгт 2: Баталгаа/зөвшөөрөл/тусгай зөвшөөрлийн үнэлгээ

Асуудлууд	Баталгааны хэлбэр (Зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, албан бичиг гэх мэт) ба батладаг эрх бүхий байгууллага	Батласан огноо		Батлагдсан баримт бичгүүд\хавсаргасан
		Хүлээн авсан	Шинэчилсэн	
Үйлдвэрийн үйл ажиллагаа (зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл гм)				
Байгаль орчны үнэлгээ			Хамаарахгүй	
Шатаах зуух/ зуухнаас ялгарах утаа, бодис				
Усан хангамж				
Хаягдал ус гаргах: <i>Хотын Үйлдвэрийн Бусад</i>				
Хаягдал зайлуулалт: <i>Аюултай бус (жишээ нь: цаас, сав боодол, мод, хуванцар гм)  Аюултай</i>				
Аюултай материалын хадгалалт, ашиглалт  (будаж, уусгагч, түлш, бусад шатамхай бодис материал гм)				
Гал түймрээс сэргийлэх				
Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа				
Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт				

### в. Байгаль орчин, нийгмийн удирдлагын гүйцэтгэлийн талаарх товчоон

*Үйлдвэрлэгчийн өнгөрсөн таван жилийн байгаль орчин, нийгмийн удирдлагын гүйцэтгэлийг үнэлэн үйлдвэрлэгчдэд Хүснэгт 3-г бөглөх хүсэлт тавина. Гүйцэтгэлийг үнэлэх гол асуудлуудад дараахи асуултууд оруулна. Үүнд:*

Үйлдвэрлэгч байгаль орчны эсвэл нийгмийн ямар нэг онцлох хариуцлага (хураамж, торгууль, шийтгэл, хуулийн арга хэмжээ /шийдвэр гаруулах) хүлээдэг /хүлээж байсан эсэх? Тухайн хүлээлгэх хариуцлагад хэрхэн ханддаг/хандаж ирсэн?

Үйлдвэрлэгч байгаль орчин эсвэл нийгмийн хариуцлагатай холбоотой ямар нэг санал гомдлыг нөлөөлөлд өртсөн орон нутгийн бүлгүүдээс хүлээн авдаг/авч байсан эсэх?

Үндэсний ба орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр эсвэл ТББ-уудаас байгаль орчны эсвэл нийгмийн удирдлагын гүйцэтгэл эсвэл үйлдвэрлэгчийн ажлын орчин нөхцөлтэй холбоотой ямар нэг санал гомдол эсвэл асуудал гарч байсан эсэх?

*Дээрх мэдээлэлд үндэслэн Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, СЯ эсвэл арилжааны банкууд үйлдвэрлэгч байгаль орчин, нийгмийн ноцтой эрсдэл гаргахаар байгаа эсэхд*

дүгнэлт гаргана. Хэрэв ямар нэг эрсдэл гарна гэж дүгнэсэн бол үйлдвэрлэгч гарах эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулахад авах арга хэмжээг тодорхойлсон байна.

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь үнэлгээний дэлгэрэнгүй тайланг гарган төслийн хавтаст хавсаргасан байна.

### Хүснэгт 3 Үйлдвэрлэгчийн байгаль орчин, нийгмийн удирдлагын гүйцэтгэлийн талаарх мэдээллийн товчоон

Торгууль/шийтгэл/санал гомдлууд			
Огноо	Асуудлын мөн чанар	Авсан ба авагдах арга хэмжээ (огноо тус бүрээр)	Санал

#### Ерөнхий үнэлгээ

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь (i) дэд төсөл хориглосон үйл ажиллагааны жагсаалт дахь үйл ажиллагааг явуулах эсэхийг тогтоох; (ii) байгаль орчин, нийгмийн эрсдэл/асуудлууд; (iii) дэд төслийн ангилал; (iv) хамрагдах боломжтой дэд төсөл бүрээр боловсруулах хамгааллын арга хэрэгслүүдийг тодорхойлох зорилгоор ерөнхий үнэлгээг хийнэ

Ерөнхий үнэлгээний маягтыг Хүснэгт 4-д оруулав.

#### Байгаль орчны

#### Хөрөнгө оруулалт

СЯ экспортлогч Дэлхийн банкны төслөөс дэмжлэг болгон авахыг хүсч байгаа ямар хөрөнгө оруулалт байгааг судалж тогтооно.

### Хүснэгт 4 Байгаль орчин, нийгмийн ерөнхий үнэлгээний маягт

Асуулт	Хариулт		“Тийм” бол ДБ-ны холбогдох бодлого	“Тийм” бол шаардлагатай баримт бичгүүд
	Тийм	Үгүй		
Дэд төслөөс байгаль орчин, нийгэмд эмзэг <sup>1</sup> , олон янзын ба урьд өмнө байгаагүй ноцтой <sup>2</sup> сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа эсэх? Товч тодорхойлолт өгнө үү:			ҮАБ 4.01 Байгаль орчны үнэлгээ  “А” ангилал	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)

<sup>1</sup> Эмзэг (жишээ нь: гол үндсэн байгалийн амьдрах орчин алдагдахад хүргэх бол нөлөөллийг эмзэг гэж үзэх, энэ тохиолдолд нөлөөлөл нь эргэн нөхөн сэргээгдэхгүй байх, иймд ҮАБ 4.04 Байгалийн амьдрах орчинд хамаарах асуудлыг үүсгэх; ҮАБ4.36, Ой; ҮАБ 4.10-Уугуул иргэд; ҮАБ 4.11-Соёлын биет нөөц; эсвэл ҮАБ 4.12-Албадан нүүлгэн шилжүүлэлт; эсвэл төсөл нь хөнөөлт шавьжны тархацыг хязгаарлахад ашигладаг бүтээгдэхүүнүүдийг их хэмжээгээр үйлдвэрлэх, ашиглах, зайлуулах бол ҮАБ 4.09 –д хамаарах асуудал үүсгэх);

<sup>2</sup> Төслийн жишээ: байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх, нөлөөлөл нь эмзэг, олон янз, урьд өмнө байгаагүй ихээхэн хэмжээний байх төслүүдэд ДЦС барих, уул уурхайн үйл ажиллагаа явуулах, хог хаягдал боловсруулах үйлдвэр, хатуу хог хаягдал цуглуулах, зайлуулах зэрэг үйл ажиллагаа орж болно.

Нөлөөлөл үйл ажиллагаа явуулж буй газар эсвэл байгууламжийн гадна тусахаар байгаа эсэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь нөхөн сэргээгдэхгүй байх эсэх? Товч тодорхойлолт өгнө үү:			<i>ҮАБ 4.01 Байгаль орчны үнэлгээ</i>  “А” ангилал	БОННУ
Төлөвлөж байгаа төсөл нь байгаль орчинд багахан эсвэл ямар ч сөрөг нөлөө <sup>3</sup> үзүүлэхгүй байх эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ОР 4.01 Байгаль орчны үнэлгээ</i>  “В” ангилал	Ерөнхий үнэлгээнээс өөр үйл ажиллагаа шаардлагагүй
Дэд төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл бага байх, зөвхөн үйл ажиллагаа хэрэгжиж байгаа газарт тусах; эсвэл тухайн нөлөөлөл нь бага ч эргэн нөхөн сэргээгдэхгүй <sup>4</sup> байх эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ОР 4.01 Байгаль орчны үнэлгээ</i>  “Б” ангилал	БОННУ эсвэл Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ)
Төсөл нь соёлын биет нөөцөд <sup>5</sup> сөрөг нөлөө үзүүлэх эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ОР 4.11 Соёлын биет нөөц</i>	БОННУ-д авч үзсэн байх (Соёлын биет нөөцийн менежментийн төлөвлөгөөг оруулсан БОННУ ба/эсвэл төслийн явцад илрүүлсэн биет олдворуудтай холбоотой журам)
Төслийн үйл ажиллагаа гол чухал бус байгалийн амьдрах орчныг өөрчлөх эсвэл доройтуулах эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ОР 4.04 Байгалийн амьдрах орчин</i>	БОННУ-д авч үзсэн байх
Төслийн үйл ажиллагаа нь гол чухал байгалийн амьдрах орчныг <sup>6</sup> өөрчлөх эсвэл доройтуулах эсэх?			<i>ОР 4.04 Байгалийн амьдрах орчин</i>	Авч үзэх боломжгүй
Дэд төсөл нь шинээр далан барих эсвэл баригдсан ба барихаар төлөвлөж буй даланг ашиглах эсэх?			<i>ОР 4.37 Далангийн аюулгүй байдал</i>	<i>Далангийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө</i>

<sup>3</sup> Төслийн жишээ: байгаль орчинд багахан хэмжээний эсвэл ямар ч сөрөг нөлөө үзүүлэхгүй байх төсөлд бараа үйлчилгээ нийлүүлэх, техникийн тусламж үзүүлэх, эвдэрсэн байгууламжид хийгдэх энгийн засвар үйлчилгээ зэрэг нь орж болно.

<sup>4</sup> ҮАБ 4.01-ийн хүрээнд “А” эсвэл “В” ангилалд ороогүй төслүүдийг “Б” ангилалд оруулж болно. “Б” ангилалын дэд төслийн жишээ: хаягдал ус цэвэршүүлэх үйлдвэр зэрэг дэд бүтцийн төслүүдийн жижиг хэмжээний газар дээрх засвар орж болно.

<sup>5</sup> Соёлын биет нөөцийн жишээнд археологийн эсвэл түүхийн холбогдолтой газрууд, түүхийн холбогдол бүхий хот суурин газрууд, шашны зан үйл бүхий газар, байгууламж эсвэл булш бүхий газрууд ялангуяа төрийн хамгаалалт бүхий газрууд орно.

<sup>6</sup> Гол чухал байгалийн амьдрах орчин тухайлбал: хуулийн дагуу хамгаалалтанд авсан ба хамгаалалтанд авахаар төлөвлөж буй газрууд, эрх бүхий байгууллагаас хамгааллын өндөр ач холбогдолтой гэж тогтоосон, эсвэл нутгийн иргэд уламжлал ёсоор хамгаалж ирсэн газруудыг өөрчлөн хувиргах эсвэл доройтуулах дэд төслүүдийг Банкны санхүүжилт дэмжлэгт авч үзэх боломжгүй.

Төсөл нь ямар нэг пестицид худалдаа хийх эсэх (төслөөр шууд эсвэл зээл олгох, хамтран санхүүжүүлэх замаар шууд бус хэлбэрээр эсвэл төрийн хамтрагч байгууллагын санхүүжилтээр дамжуулан), эсвэл пестицидийн худалдаа хийх төлөвлөгөөгүй ч хөнөөлт шавьжны менежментэд хор нөлөө үзүүлж болох эсэх?			<i>ОР4.09 Хөнөөлт шавьжны менежмент</i>	БОННУ-д авч үзсэн байх  (Хөнөөлт шавьжны менежментийн төлөвлөгөө)
Дэд төсөл нь албадан газар чөлөөлүүлэх, өмч хөрөнгийг алдагдуулах эсвэл орлого, амьжиргааны эх үүсврийг алдагдуулахад хүргэх эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ОР 4.12 Албадан нүүлгэн шилжүүлэлт</i>	Нүүлгэн шилжүүлэлт (НШ)-ийн хураангуй төлөвлөгөө/ НШ-ийн төлөвлөгөө <sup>7</sup> (Журмын талаарх дэлгэрэнгүйг Хавсралт В-ээс харна уу).
Дэд төсөл хэрэгжих газарт цөөнхийн бүлэг амьдардаг ба төслийн үйл ажиллагаа тэдэнд сөрөг эсвэл эерэг нөлөө үзүүлэх эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ҮАБ 4.10 Уугуул иргэд</i>	Нутгийн цөөнхи бүлэгт чиглэсэн хөгжлийн төлөвлөгөө /Уугуул иргэдэд чиглэсэн төлөвлөгөө  (Журмын талаарх дэлгэрэнгүйг Хавсралт Б-ээс харна уу).
Төсөл нь ойтой холбоотой үйл ажиллагаа явуулснаар ойн эрүүл мэнд, чанарт нөлөөлөх эсвэл нутгийн иргэдийн эрх, сайн сайхан, бие даасан байдалд нөлөөлөх эсэх; эсвэл байгалийн ба таримал ойн менежмент, хамгаалал, ашиглалтыг өөрчлөхийг зорьж байгаа эсэх? Товч үндэслэл тайлбар өгнө үү:			<i>ҮАБ4.36 Ойн аж ахуй</i>	БОННУ-д авч үзсэн байх
Төсөл нь байгалийн гол чухал ой ба бусад амьдрах орчинг өөрчлөн хувиргах ба доройтуулах нөлөө үзүүлэх эсэх?			<i>ОР4.36 Ойн аж ахуй</i>	Авч үзэх боломжгүй
Дэд төсөл, түүнтэй холбоотой асуудал ба үйл ажиллагаанд хоёр ба түүнээс дээш тооны улс орнуудын хооронд ямар нэг газар нутгийн маргаан байгаа эсэх?			<i>ҮАБ 7.60 Маргаантай газруудад хэрэгжих төслүүд</i>	Тухайн улс орны төр засгийн газартай тохиролцох
Дэд төсөл, түүнтэй холбоотой асуудал ба үйл ажиллагаа, тэдгээрийн нарийвчилсан дизайн, инженерийн судалгаа нь олон			<i>ҮАБ7.50 Олон улсын усан замын төслүүд</i>	Мэдэгдэх, зарлах  (эсвэл тухайн нөхцөлд авч үзэх зүйл)

<sup>7</sup> Хэрэв төслийн дэмжлэг авах аливаа дэд төслийн хүрээнд бага хэмжээний нүүлгэн шилжүүлэлт хийгдэх (жишээ нь: нөлөөлөлд өртөх хүмүүс өөр газарт шилжин суурьшаагүй, тэдний хөрөнгийн 10 хүрэхгүй хувь төслийн нөлөөгөөр алдагдах) эсвэл 200 хүртэл хүмүүс газар чөлөөлөлтөнд өртөх бол нүүлгэн шилжүүлэх газар тогтоогдсон тохиолдолд үйлдвэрлэгч үйл ажиллагааг эхлүүлэх ба дэд төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө нэг ба түүнээс дээш тооны нүүлгэн шилжүүлэлтийн хураангуй төлөвлөгөө гаргана. Хэрэв төслөөс үзүүлэх нөлөө бага биш ба 200-аас дээш тооны хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхээр байгаа бол үйлдвэрлэгч үйл ажиллагааг эхлүүлэх ба дэд төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө нэг ба түүнээс дээш тооны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө гаргана.

улсын усан зам <sup>8</sup> ашиглах, бохирдол үүсгэх, эсвэл тухайн замд байрлах эсэх?				
---	--	--	--	--

### Хамгааллын баримт бичиг

Байгаль орчны

Хөрөнгө оруулалт

Экспортлогч бүр байгаль орчны хамгааллын холбогдох бүх баримт бичгийг боловсруулан гаргах үүрэг хүлээнэ.

Төслийн хүрээнд хөрөнгө оруулалт, дэмжлэгийг ихээр авах “Б” ангилалын хөрөнгө оруулалтын тухайд Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) гаргахыг шаардаж болно. Дэлхийн банкны БОНМТ-ний загварыг Хүснэгт 5-д харуулав.

### Хүснэгт 5 Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний загвар

Асуудал	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Холбогдох стандартууд		Нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны зардал	Хариуцах эзэн	Эхлэх хугацаа (огноо)	Дуусах хугацаа (огноо)
		Монгол улсын	Монгол улсын				
<b>БҮТЭЭН БАЙГУ УЛАЛТЫН ҮЕ ШАТ</b>							
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ША Т</b>							

“А” ангилалд хамаарах хөрөнгө оруулалтын тухайд Дэлхийн банкны БОНБУ явуулах шаардлагатай. Тус БОНБУ-ний баримт бичигт тусгах агуулгыг Хавсралт В-д оруулав<sup>9</sup>.

(Жич: тодорхой салбарын үйлдвэрлэлд чиглэсэн хөрөнгө оруулалтын тухайд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлаар Дэлхийн банкны аргачлал<sup>10</sup> эсвэл Монгол улсын стандарт, дүрэм журмын аль илүү хатуу чанга заалтыг баримтлахыг шаардана).

### Олон нийтийн хэлэлцүүлэг ба мэдээллийг ил тод нээлтэй болгох үйл ажиллагаа

БОНБУ/БОМТ-ний төсөл, нутгийн иргэд, цөөнхийн хамгааллын ба/эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөг нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэд, ТББ-уудад танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулна.

Экспортын үйлдвэрлэл эрхлэгч нь олон нийтийн хэлэлцүүлгийг явуулах үүрэг хүлээнэ. Дэлхийн банк нь байгаль орчин эсвэл нийгмийн багаас дунд зэргийн эрсдэл бүхий төслүүдээс наад зах нэг

<sup>8</sup> Олон улсын усан замд хоёр ба түүнээс дээш тооны улс орны нутаг дэвсгэрээр дамжин урсан гол мөрөн, гадаргын ус, суваг, нуур ба тэдгээртэй адил уст цэгүүд, тэдгээрийн хилийн зааг орно.

<sup>9</sup> Дэлхийн банкны Үйл ажиллагааны бодлого 4.01, Хавсралт Б: “А” ангилалд орсон төслийн байгаль орчны үнэлгээний тайлангийн агуулгыг харах

<sup>10</sup> [www.ifc.org/ifcext/sustainability.nsf/content/EHSGuidelines-r](http://www.ifc.org/ifcext/sustainability.nsf/content/EHSGuidelines-r) харах.



удаа нөлөөлөд өртөгч бүлгүүд, ТББ-уудтай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахыг шаарддаг. Харин эрсдэл өндөртэй төслүүд (“А” ангилалын)-ийн тухайд олон нийтийн хэлэлцүүлгийг хамгийн багадаа хоёр удаа зохион байгуулах шаардлага тавьдаг. Эхний хэлэлцүүлэгт байгаль орчин, нийгмийн хамгааллын баримт бичгүүд (БОНБУ, Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, нутгийн иргэд цөөнхийн хамгааллын төлөвлөгөө)-д тусгах асуудлууд, харин хоёр дахь хэлэлцүүлэгээр эхний хэлэлцүүлгээр ярилцаж хэлэлцсэн асуудлуудыг хамгааллын баримт бичгүүдэд хэрхэн тусгах талаар хэлэлцэнэ.

Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчид нь хамгааллын баримт бичгүүдээ олон нийтийн газрууд (номын сан, хотын захиргаа эсвэл төр засгийн байгууллагуудын байр гэх мэт), үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа явуулдаг газрын ойролцоо газрууд болон түүний вэб хуудснаа мэдээлэл байрлуулж, орон нутгийн ба үндэсний мэдээллийн хэрэгсэл (жишээ нь: сонин)-ээр тухайн баримт бичгүүдийн талаар мэдээлэл танилцуулга хийх ажлыг зохион байгуулдаг байх хэрэгтэй. Хэрэв шаардлагатай бол Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани эсвэл СЯ мэдээллийг хэрхэн олон нийтэд хүргэх, ил тод болгох арга замын талаар Дэлхийн банктай хэлэлцэж болно. Экспортын үйлдвэрлэл эрхлэгчид нь хамгааллын баримт бичгүүдийг олон нийтэд танилцуулсан ажлын он сар өдөр, байршил, арга хэлбэрийн талаар мэдээлсэн албан бичгийг Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд эсвэл СЯ-нд ирүүлдэг байх хэрэгтэй. Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь уг албан бичгийг төслийн хавтаст хавсаргана.

Түүнчлэн хэрэв экспортын үйлдвэрлэл эрхлэгчтэй Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани эсвэл СЯ тухайн хамгааллын баримт бичгүүдийг өөрсдийн вэб хуудснаа байрлуулж, тухайн баримт бичгүүдийг олон нийтэд хэрхэн хүргэсэн талаарх тэмдэглэлийг төслийн хавтаст хавсаргана.

### **ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

- Олон нийтийн хэлэлцүүлэг зарлагдсан хэлбэр:
  - Хэвлэл мэдээлэл (сонин, ТВ, радио)
  - Зарласан огноо (ууд)
  - Зарын хувь (хэрэв байгаа бол)
- Хэлэлцүүлэг явуулсан огноо (ууд)
- Хэлэлцүүлэг явуулсан газар (ууд)
- Оролцсон/холбоо барьсан хүмүүсийн нэрсийн жагсаалт
- Оролцсон хүмүүсийн нэрсийн жагсаалт
- Хэлэлцүүлэг явуулсан арга хэлбэр
  - Олон нийтийн уулзалт
  - Санал асуулга
  - Судалгаа
  - Бусад
- Хөтөлбөр /програм
- Тэмдэглэл (санал, асуулт, дэвшүүлсэн асуудлууд, үйлдвэрлэгчийн өгсөн хариулт)
- Гаргасан шийдвэр, харилцан тохиролцсон арга хэмжээ (хуваарь, хариуцах эзэн)

### **Хяналт ба баталгаажуулалт**

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь хамгааллын баримт бичгүүдийг Дэлхийн банкны холбогдох бодлогуудтай нийцүүлэн боловсруулсан эсэхт хянаж, батлах үүрэг хүлээнэ. Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ нь олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр тавигдсан гол асуудлуудыг хамгааллын баримт бичгүүдэд тусгасан эсэхт хяналт тавина.

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд эсвэл СЯ хамгааллын баримт бичгүүдийг хянаж, батласны дараа тухайн баримт бичгүүдийг батласан тухай албан бичгийг холбогдох үйлдвэрлэгчдэд хүргүүлж, албан бичгийн хуулбарыг төслийн хавтаст хавсаргана.

“А” ангилалд хамаарах БОНБУ шаардах үйл ажиллагаа ба/эсвэл Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, ба/эсвэл Уугуул иргэдийн хамгааллын хөтөлбөрийг СЯ-аар батлуулахын өмнө эхлээд Дэлхийн банкинд хүргүүлэн хянуулж, “татгалзах зүйлгүй” гэдгийг тогтоолгосон байна.

## Хууль/гэрээний үүрэг

Хамгааллын баримт бичгүүдэд зөвлөмж болгон оруулсан бүх үйл ажиллагааг экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчидтэй тохиролцсны дагуу санхүүгийн арга хэрэгслүүдэд гэрээний үүрэг болгон оруулах. Цаашид Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд, СЯ-тай тохиролцсны дагуу зөвлөмж болгосон үйл ажиллагаа бүрийг хамгааллын баримт бичгүүдэд заасан хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд үйлдвэрлэгчдэд үзүүлэх санхүүгийн арга хэрэгслийг зогсоох, хүчингүй болгох үндэслэл болгохоор тэдэнтэй хийх гэрээнд зааж өгөх.

## Мониторинг ба тайлагнах үйл явц

Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь үйл ажиллагааны явцаа байнга тайлагнадаг байх үүднээс хамгааллын баримт бичгүүдэд тусгасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийн явцын талаар товч мэдээлийг СЯ эсвэл Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани эсвэл арилжааны банкуудад хүргүүлдэг байна. Уг мэдээлэлд хэрэгжилтийн явцын талаар тусгахаас гадна ямар нэг дэвшүүлэн тавьсан асуудал болон тэдгээрийг шийдвэрлэсэн арга зам, хугацааг оруулсан байна. Түүнчлэн үйлдвэрлэгч нь өөрөө Хүснэгт 6-д өгсөн загварыг ашиглан байгаль орчин, нийгмийн хамгааллын мониторинг байнга явуулдаг байна.

Түүнчлэн үйл ажиллагааны байнгын хяналт үнэлгээний нэг хэсэг болгон Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд эсвэл СЯ нь үйлдвэрлэгчийн байгаль орчин, нийгмийн удирдлагын үүргээ хэрэгжүүлж байгаа байдал, ажлын гүйцэтгэлд хяналт тавина. Нийгэм ба/эсвэл байгаль орчны эрсдэл өндөртэй төслүүдийн хувьд эрсдлийн түвшнээс хамааруулан Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани, арилжааны банкууд эсвэл СЯ нь байгаль орчин, нийгмийн удирдлага, түүний гүйцэтгэлд хяналт тавьж үнэлүүлэх үүднээс бие даасан хөндлөнгийн багийг ажиллуулна.

## Хүснэгт 6. Мониторингийн төлөвлөгөөний загвар

Ямар өгөгдөхүүнийг хэмжих	Хаана өгөгдөхүүнийг хэмжих	Хэрхэн өгөгдөхүүнд мониторинг хийх (ашиглах тоног төхөөрөмж)	Хэзээ Мониторингийн давтамж буюу үргэлжлэх байдал	Мониторингийн зардал Тоног төхөөрөмжийн зардал буюу гүйцэтгэгчийн төлбөр	Хариуцах эзэн	Эхлэх хугацаа (огноо)	Дуусах хугацаа (огноо)
Б ҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ҮЕ ШАТ							
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ							

## **Гомдол шийдэх механизм**

Дэд төслүүдийн гомдол шийдэх механизм нь өөрсдийгөө төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж байна гэж үзэж байгаа хүмүүс, тэдгээрийн бүлгүүдээс тавьж буй асуудлуудыг авч үзэхэд чухал үүрэгтэй. Тус механизмд дараахи зүйлийг тусгаж болно. Үүнд:

- Аман ба бичгээр ирүүлсэн гомдол саналуудыг бүртгэх ба мэдээлэх тогтолцоо;
- Төр засгийн төрөл бүрийн түвшний холбогдох ажилтнууд;
- Бүртгэж хүлээн авсан гомдол саналуудыг авч үзэх хугацааг оруулсан байна.

Уг механизмыг дэд төслийн хамгааллын баримт бичгүүдэд нарийвчлан авч үзсэн байна. Маргаан гарах тохиолдолд юуны өмнө оролцогч талуудын дунд асуудлыг шийдэх арга замыг хайна. Хэрэв тохиролцоонд хүрч чадахгүй бол маргааныг шийдүүлэхээр шүүхэд хандаж болно.

# ХАВСРАЛТ А. ҮНДЭСНИЙ ЦӨӨНХИЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭ (ҮЦХХ)

## 1. Танилцуулга, оршил

Монгол Улсын Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани болон холбогдох арилжааны банкнаас дэмжлэг үзүүлэх эсхүл Сангийн яамнаас гаргасан зохих грантын үйлчилгээнээс үр ашиг хүртэх экспортлогч аж ахуйн нэгжийн мөн чанар, төрөл нь одоогоор тодорхой бус байна. Иймээс дэд төсөл хэрэгжиж байгаа газарт үндэсний цөөнхи байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Үндэсний цөөнх байгаа газарт төслийн дэмжлэгтэйгээр аливаа экспортлогч аж ахуйн нэгж байгуулагдаж, эсвэл тухайн газарт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд Үндэсний цөөнхийн төлөвлөгөөг бэлтгэхийн тулд Үндэсний цөөнхийн хөгжлийн хүрээг боловсруулсан байна.

ҮЦХХ нь Дэлхийн банкны “ҮАБ 4.10- Уугуул иргэд” гэсэн бодлогын дагуу бэлтгэгдсэн байна.

Энэхүү ҮЦХХ-нд хэрэглэгдсэн үндэсний цөөнх хэмээх тодорхойлолт нь нийгэм, соёлын ялгаатай эмзэг бүлгийг хэлнэ. Энэхүү бүлэг нь дараах онцлогтой:

- Өөрсдийгөө бусад хүмүүс хүлээн зөвшөөрсөн өвөрмөц соёл бүхий уугуул иргэд гэж үздэг;
- Төсөл хэрэгжүүлж буй нутаг нь газар зүйн хувьд ялгаатай, өвөг дээдсээс уламжилж ирсэн нутаг бөгөөд тухайн газрын байгалийн нөөц баялагтай салшгүй холбоотой хүмүүс
- Зонхилох нийгэм, соёлоос тусгаарлагдсан уламжлалт соёл, эдийн засаг, нийгэм, улс төрийн нэгдэл
- Улс орон эсхүл бүс нутгийн албан ёсны хэлнээс ялгаатай уугуул хэлтэй

Монгол улсын үндэсний цөөнх

Дэлхийн банкны бодлого 4.10- Уугуул иргэд гэсэн бодлогын тодорхойлолтонд Монгол улсад дараах угсаатны бүлгүүдийг хамруулж үзнэ:

### (i) Цаатан

Цаатангууд нь Хөвсгөл *аймгийн* хойд хэсэгт оршдог тайгын ойд үе уламжлан амьдардаг. Тэдний уламжлалт амжиргаа нь цаа буга өсгөн үржүүлэхэд суурилдаг.

### (ii) Казак

Монгол улсын хүн амын 4.3 хувийг эзэлдэг Казакууд нь Монгол орны баруун хэсэгт амьдардаг хамгийн том үндэсний цөөнх юм. Казакууд нь Түрэг угсааны бөгөөд өөр хэлээр ярьдаг ганц үндэстэн.

## 2. Уугуул иргэдтэй холбоотой хууль эрхзүйн болон зохион байгуулалтын хүрээ

Үндэсний цөөнхийн эрх нь Монгол улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан байдаг. Үүнд: “*Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно*” гэж заажээ. Монгол улсын Үндсэн хууль, 1992, 2-р бүлэг, 14-р зүйл.

Үндэсний цөөнхөд тусгайлан зориулсан үүнээс өөр хууль, тогтоомж засгийн газрын ямар ч түвшинд гараагүй байна.

## 3. Журам

### Уугуул иргэдтэй үүлзалт зөвлөгөөн зохион байгуулах

ҮАБ 4.10 дагуу, Дэлхийн Банкны төслөөр дэмжлэг үзүүлэхэд төслийн зээлдэгч нь чөлөөтэй, урьдчилан мэдээлсэн зөвлөлдөх үйл ажиллагааг зохион байгуулахыг шаардана. Энэ нь уугуул иргэд хамтран санал бодлоо илэрхийлж төсөлд олон нийтийн дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

Төслийн онцлогоос хамаарч уулзалт зөвлөгөөн хийх арга, аргачлал, цар хүрээ нь ялгаатай байж болно.

Уугуул иргэдийн тоо буюу тархан суурьшсан байдал нь түүврийн аргаар зөвлөгөөн хийхийг шаардаж байгаа бол тодорхой зөвлөгөөн хийх стратегийг зохих төлөөллийг хангаж чадахуйцаар боловсруулна. Зөвлөгөөн хийх ажлыг дараах байдлаар ерөнхийдөө зохион байгуулна:

- a) Уугуул иргэд өөрийн санал бодлоо ямар нэг сүрдүүлэлт, дарамт шахалтгүйгээр ил тод илэрхийлэх бололцоотой зохион байгуулах
- b) Уугуул иргэдийн дэвшүүлсэн санал буюу асуудлыг төслийг батлах шийдвэр гаргах эсхүл хэрэгжүүлэхээс өмнө цаг тухайд нь авч үзэх
- c) Уугуул иргэд төслийн талаар зохих мэдээлэл хангалттай авч, саналаа хэлэх бололцоотой болсны дараа зохион байгуулах
- d) Нутгийн ёс заншлын улмаас олон нийтийн уулзалтанд оролцож болохгүй байж магадгүй эмэгтэйчүүд, настай хүмүүсийн санал бодлыг авах шаардлагатай тохиолдолд тэднийг хамруулсан зөвлөгөөнийг тусад нь зохион байгуулах

Уулзалт зөвлөгөөн бүрт тэмдэглэл хөтөлж, дүгнэлт (он сар өдөр, байршил, оролцсон хүний тоо, нийгмийн байдал, хэлэлцсэн асуудлын хураангуй) гаргана.

Зөвлөгөөнийг нийгмийн үнэлгээний үйл явцын нэг хэсэг эсхүл тусгай багц үйл ажиллагааны хэлбрээр явуулж болно.

#### Нийгмийн үнэлгээ

Нийгмийн үнэлгээ нь Уугуул иргэдийн төлөвлөгөө (УИТ) бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай алхам юм. Нийгмийн үнэлгээний арга зүйн асуудал, цар хүрээ, нарийвчлалын түвшин нь төсөлтэй холбоотой эрсдэл, сөрөг нөлөөллийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байна. Нийгмийн үнэлгээ нь төслийн ерөнхий үнэлгээ хийх явцад тогтоосон эсхүл ажлын даалгаварт заасан уугуул иргэдтэй холбоотой асуудалд онцгой анхаарна. Нийгмийн үнэлгээ нь тусдаа бие даасан баримт бичиг хэлбрээр эсхүл Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй хамт хийгдэж болно. Нийгмийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд дараах зүйлс орно:

- a) Төслийн тодорхойлолт, уугуул иргэдтэй холбоотой болзошгүй асуудлууд болон нөлөөлөх хүчин зүйл
- b) Төслийн онцлогт тохирсон уугуул иргэдэд хэрэглэх боломжтой зээлдэгчийн хууль эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын тойм
- c) Нийгмийн үнэлгээний явцад зөвлөгөөнд оролцох уугуул иргэд болон бусад гол оролцогч талуудыг тодорхойлох
- d) Уугуул иргэдтэй холбогдох хүн ам зүй, нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн суурь мэдээлэл
- e) УИТ бэлтгэх, төсөл хэрэгжүүлэх хугацаанд уугуул иргэдэд хийх нээлттэй, чөлөөтэй, урьдчилан мэдээлсэн зөвлөгөөнд соёлын онцлогийг нь харгалзаж үйл ажиллагаа явуулах
- f) Уугуул иргэдтэй хийх зөвлөгөөний үндсэн дээр төсөлтэй холбоотой гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, үр ашгийн үнэлгээ хийх
- g) Төслийн зорилго, төслийн үр ашгийн хүртээмж, соёлын зохимж, аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, төслийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой уугуул иргэдийн санал бодол, асуудлын хураангуй

#### Иргэдийн нийтлэг дэмжлэгийг илэрхийлсэн мэдэгдэл

Зөвлөгөөн болон нийгмийн үнэлгээний үр дүнд тулгуурлан аж ахуйн нэгжийн удирдлага нь холбогдох уугуул иргэдийн дунд олон нийт төслийг өргөн дэмжиж буй эсэхийг тодорхойлно. Уг тодорхойлолт нь төслийн зорилго, төлөвлөгөө, хэрэгжилтийн зохион байгуулалтыг дэмжсэн хамт олны санаа бодол болон албан бус илэрхийлэл дээр тулгуурлана. Энэхүү тодорхойлолтонд бүх

хүн санал нэгтэй байх албагүй; бүлгийн дотор дотоодын санал зөрчилдөөн эсхүл төслийн зорилго, санал болгож буй арга хэмжээний талаар хязгаарлагдмал тооны сөрөг хүчин байсан ч гэсэн төслийг олон нийт дэмжиж болно. УИТ-нд тодорхойлолт хийсэн үндэслэлийг тайлбарлана.

### Уугуул иргэдийн төлөвлөгөө

УИТ-г төслийн агуулагт тулгуурлан уян хатан, прагматик байдлаар бэлтгэнэ. УИТ-нд шаардсан цар хүрээ, нарийвчлалын түвшин нь төсөлтэй холбоотой эрсдэл, сөрөг нөлөөллийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байна. Нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан нь УИТ нь зөвхөн тодорхой нэг бүлэгт хамаарах асуудал дээр төвлөрөх юм уу эсхүл УИТ-ийн элементүүд нь олон угсаатан хамарсан, хамтын оролцоонд тулгуурласан илүү өргөн төлөвлөгөө байж болно. УИТ-д дараах элементүүд орно:

- a) Төслийн тодорхойлолт, уугуул иргэдтэй холбоотой асуудлын товч тодорхойлолт
- b) Холбогдох асуудлын товч хураангуй, нийгмийн үнэлгээнээс гарсан үр дүн
- c) Уугуул иргэдэд хийсэн нээлттэй, чөлөөтэй, урьдчилан мэдээлсэн зөвлөлгөөнөөс гарсан үр дүнгийн хураангуй, олон нийтийн дэмжлэгийн тодорхойлолтын тойм
- d) Уугуул иргэдэд соёлын зохих үр ашгийг тэгш хүртэх боломжийг хангах арга хэмжээ
- e) Уугуул иргэдэд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, эрс багасгах, эсхүл бууруулах арга хэмжээ
- f) УИТ-г хэрэгжүүлэх зардлын тооцоо, төсөв, санхүүгийн хариуцлага
- g) Уугуул иргэдийн (хувь хүн буюу хамт олны) гаргасан гомдлыг барагдуулах хүртээмжтэй, соёлын зохистой хэрэгсэл
- h) Хяналт зохицуулалт
- i) Мэдээллийг ил тод болгох арга хэмжээ

МУ-ын ХААДДХК, СЯ, арилжааны банкууд нь төслөөс дэмжлэг авч буй аж ахуйн нэгжийн байршил, тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй газар, шинж чанарыг хянах үүрэг хүлээнэ. Дэд төсөл хэрэгжих газарт үндэстний цөөнх байгаа нөхцөлд МУ-ын ХААДДХК, СЯ, арилжааны банк нь тухайн байдлаас шалтгаалан үндэстний цөөнхийн төлөвлөгөө гаргахыг төслөөс дэмжлэг авч буй аж ахуйн нэгжээс шаардана. Төлөвлөгөөг нөлөөлөлд өртсөн үндэстний цөөнхтэй зөвшилцөж гаргах бөгөөд энэ нь төслийн олон нийтийн дэмжлэгийн талаархи хамт олны санал бодлын илэрхийлэл болно. Ерөнхийдөө, зөвлөлдөх үйл явц нь:

ҮЦХХ нь ҮЦ-д хүртээмжтэй, соёлын хувьд зохистой байдлаар олон нийтийн газарт нээлттэй, ил тод байна. Үүнтэй нэгэн адил, ҮЦХХ-нд үндэстний цөөнхийн төлөвлөгөөг бэлтгэх үед холбогдох банк болон аж ахуйн нэгж нь уг төлөвлөгөө олон нийтэд ил тод байгаа талаар шалгуулахаар Дэлхийн банкинд илгээнэ.

## ХАВСРАЛТ В. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭ (НШБХ)

### 1. Танилцуулга, оршил

Монгол улсын Экспортын хөгжлийн төсөл нь барилга байгуулалтын ажлыг дэмжихгүй учир ямар нэг нүүлгэн шилжүүлэлт эсхүл биет болон эдийн засаг, нийгмийн эд хөрөнгийн алдагдал гарч болох аливаа газрыг эзэмшихгүй. Монгол Улсын Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувьцаат компани (МУХААДДХК)-ны шугамаар арилжааны банкаар дамжуулан санхүүжилт, экспортын үйлчилгээ эсхүл Сангийн яам (СЯ)-ны санхүүгийн дэмжлэг хүлээн авч буй аж ахуй нэгж нь газрыг албадан авахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нөхцөлд энэ НШБХ-г хэрэгжүүлнэ. Тухайлбал, аж ахуй нэгж нь экспортыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх шаардлагатай болох гэх мэт.

Төслийн үнэлгээнд төслөөс үр ашиг хүртэх магадлалтай аж ахуй нэгж, тэдний үйл ажиллагаа болон байгууллагын талаарх мэдээлэл тодорхой бус учир Дэлхийн банкны ҮАБ 4.12 -Нүүлгэн шилжүүлэх бодлогын дагуу Монгол улсын Экспортын хөгжлийн төсөлд зориулж энэ НШБХ-г боловсруулав.

Энэхүү НШБХ нь газар эзэмшилт, нүүлгэн шилжүүлэлтийг хамарсан дэд төслүүдийн хувьд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (НШҮАТ) болон нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны хураангуйлсан төлөвлөгөө (НШҮХАТ)-нд хамаарах баримт бичгийг боловсруулахад ашиглах зарчим, зорилго, журам, дүрмийг тогтооно.

Одоо байгаа байрнаасилүү газар эзэмших, нүүлгэн шилжүүлэх ажил хийх дэд төслүүд нь энэхүү Нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээний дагуу нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө эсхүл нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны хураангуйлсан төлөвлөгөө боловсруулж, хянуулж, батлуулахаар Дэлхийн банкинд хүргүүлнэ.

**НШҮАТ ба НШҮХАТ.** Хэрэв төслийн дэмжлэг авсан дэд төсөл нь албадан нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл багатай (нөлөөлөлд өртсөн хүмүүс биеэр шилжин нүүгээгүй, тэдний үйлдвэрийн эд хөрөнгийн 10-аас доошгүй хувь нь алдагдсан) эсхүл 200-гаас цөөн хүн шилжин суурьшсан тохиолдолд аж ахуйн нэгж нь ямар нэгэн ажил буюу дэд төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө төслийн тодорхой байршлаа мэдэж байгаа үед нэг эсхүл олон тооны нүүлгэн шилжүүлэлтийн хураангуйлсан төлөвлөгөө (НШХТ) бэлтгэх. Хэрвээ төслийн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл их, 200-гаас олон хүн шилжин суурьших тохиолдолд аж ахуйн нэгж нь аливаа нэг ажил буюу дэд төслийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө төслийн тодорхой байршлаа мэдэж байгаа үед нэг эсхүл олон нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (НШТ) боловсруулна.

### ҮАБ 4.12 –ын зорилго, гол зарчмууд

**Зорилго.** Дэлхийн банкны дэмжлэгтэй төслүүдэд нийгмийн сөрөг нөлөөлөл, түүнчлэн албадан нүүлгэн шилжүүлэлт, газар эзэмшилтэй холбоотой сөрөг нөлөөлөлөөс зайлсхийх, багасгах, нөхөн олговор олгох зэрэг зайлшгүй шаардлагатай бүх арга хэмжээнүүдийг зээлдэгч авна.

Албадан нүүлгэн шилжүүлэлтээс аль болох зайлсхийх, эсхүл багасгахын тулд төслийн дизайны үр ашигтай хувилбар бүрийг судалж үзэх хэрэгтэй.

Албадан нүүлгэн шилжүүлэлтээс аль болох зайлсхийх боломжгүй бол нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн хүмүүстэй ойр зөвлөлдөх, тогтвортой хөгжлийн хөтөлбөр болгож нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх хангалттай нөөцтэй байх ёстой.

Төслийн нөлөөлөлд өртсөн, түүний дотор нүүж шилжсэн бүх хүмүүст нүүлгэн шилжүүлэхээс өмнө байсан аж амьдрал, амжиргааны түвшин эсхүл төсөл хэрэгжихийн өмнөх байдалтай дүйцхүйцтүвшинд хүрэх, улмаар сайжруулах гэсэн тэдний хүчин чармайлтыг дэмжин туслах хэрэгтэй. Үүнийг а) эд хөрөнгийн хохирлыг бүрэн орлох өртгийг нөхөн төлөх (жишээ нь, газар, хурааж аваагүй ургац, эзэмших газрыг сайжруулах г.м.), б) ҮАБ 4.12-н дагуу шаардлагатай

тохиолдолд аж амьдралыг сэргээх, биеээр шилжин суурьших бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх замаар шийдвэрлэнэ.

## **2. Монгол улсын хууль эрхзүй, бодлогын хүрээ**

Урьд нь газрын эрх Монгол улс Засгийн газрын мэдэлд байсан. 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэнээр газрыг улс зохицуулдаг онцгой эрх мэдэл суларсан. Одоогийн байдлаар газрын нилээд хэсэг хувьчлагдсан байна. Албадан нүүлгэн шилжүүлэлт болон газартай холбоотой асуудлыг Монгол улсын дараах хууль тогтоомжинд тодорхойлсон байна.

Нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой газрын тухай үндэсний хууль тогтоомж:

**(a) Монгол улсын үндсэн хууль (УИХ-н тогтоол No. 41, 1990 оны 10 дугаар сарын 27)** Энэ хууль нь Монгол Улсын иргэн хувийн өмчтэй байх, эрүүл, аюулгүй, орчинд амьдрах, материаллаг болон санхүүгийн туслалцаа авах онцгой эрхийг баталгаажуулсан байна.

**(b) Газрын тухай хууль (УИХ-н тогтоол No. 56, 1994 оны 11 дүгээр сарын 11)**

Энэ хуулийн 29 дугаар зүйл нь иргэн гэр бүлийн хэрэгцээнд зориулан оршин суугаа газартаа 0,07 га (700 м<sup>2</sup>)-аас илүүгүй хэмжээтэй талбайг хашиж эзэмшиж болно гэж заасан.

**(c) Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль** Монгол Улсын иргэн засаг захиргааны нэгжээс гаргасан тогтоомж, шийдвэрийн талаар хүлээсэн үүргээ санаатайгаар зөрчсөн тохиолдолд түүнд засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

**(d) Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль (УИХ-н тогтоол No. 35, 1997 оны 7 дугаар сарын 7)**

Энэхүү хууль тогтоомжийн дагуу хот болон түүний дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын мастер төлөвлөгөөнд заасан газрыг хотын хэрэгцээнд ашиглаж болно.

**(e) Хотын нутаг дэвсгэрт газар эзэмших, түрээслэх журам (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр No. 86, Хавсралт 1,2, 1995 оны 12 дугаар сарын 29,)** Монгол Улсын иргэн нь хотын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээнд зориулан 0.05 га-гаас илүү хэмжээний газар эзэмшиж байгаа тохиолдолд энэ хэмжээг хуульд заасны дагуу багасгах ёстой.

**(f) Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газартай холбоотой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд хяналт тавих тухай (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр No.19, 1995 оны 3 дугаар сарын 20)**

Монголын ард түмний газар ашиглах эрх нь газар ашиглах, өмчлүүлэх зохих хууль, журмын дагуу хамгаалагдсан байна.

**(g) Хотын захиргаа, дүүргийн тусгай хэрэгцээнд зориулж газар эзэмших (Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр No.96, 2000 оны 7 дугаар сарын 18)**

Хотын захиргаа, дүүрэг нь инженерийн бүтэц, шугам хоолой, дэд бүтэц, барилгын хөгжүүлэх зорилгоор тусгай хэрэгцээнд газар авах эрхтэй байна.

**(h) Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 27)**

Энэ хуулийн 40 дүгээр зүйл нь Засгийн газар улсын тусгай хэрэгцээг үндэслэн иргэний өмчилсөн газрыг нөхөн олговортойгоор солих юм уу буцаан авч байгаа тохиолдолд Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг баталгаажуулна. Энэ зүйлд нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой бусад заалтуудыг тусгасан байна. Хамгийн чухал заалт болох 40.2-т зааснаар Засгийн газар иргэний газрыг эзэмшихээс өмнө дор хаяж нэг жилийн өмнө мэдэгдэл өгсөн байх ёстой.

**(j) Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт (2008 оны 5-р сарын 22)**

Энэ хуулийн 19.1.2-р зүйл нь 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн гэр бүлийн гишүүн бүр газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчилж авах баталгаа гаргасан.

## **3. Монгол улсын хууль эрхзүйн орчинг Дэлхийн банкны ҮАБ 4.12 бодлоготой харьцуулсан**

Дэлхийн банкны нүүлгэн шилжүүлэх бодлого (ҮАБ/ББ 4.12) нь тухайн улсын одоо байгаа газар эзэмших, нүүлгэн шилжүүлэх бодлогыг Дэлхийн Банкны нүүлгэн шилжүүлэх бодлоготой харьцуулж үнэлэхийг шаарддаг. Дэлхийн Банкны бодлого нь Монгол Улсын хуулиас ялгаатай гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс (ӨХ) түүний дотор газар өмчлөх хууль ёсны хүчин төгөлдөр эрхийн бичигтэй эзсхүл эрхгүй төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг хамруулна.



- Хүмүүс албадан нүүлгэн шилжүүлэлт эсхүл эд хөрөнгийн алдагдлын улмаас хохирол амсдаг учраас аж амьдрал, амьжиргааны түвшинг сэргээх, бүрэн орлох нөхөн төлбөрийг олгох эсхүл бусад газарт нүүн шилжихэд нь туслах шаардлагатай.

#### **4. НШБХ-ний хэрэгжилт**

МУ-ын ХААДДХК, СЯ нь тэдний дэмжлэгтэй дэд төсөл нь албадан нүүлгэн шилжүүлэхэд хүргэж болох эсэхийг үнэлэх үүрэг хүлээнэ. Харин экспорт хийдэг аж ахуйн нэгж, экспортыг нэмэгдүүлэх банкууд нь газар эзэмших ямар нэг үйл ажиллагаа байгаа бол энэ талаараа МУ-ын ХААДДХК, СЯ-д гэрээ ёсоор тайлагнаж байх үүрэг хүлээнэ.

#### **5. Ил тод байдал ба олон нийтийн зөвлөгөөн**

Ил тод байдал, олон нийтийн зөвлөгөөн нь НШБХ-ний хэрэгжилтийн гол элемент юм. Дэд төсөл хэрэгжүүлэгч эсвэл бизнес эрхлэгч нар оролцогч бүх талуудад мэдээлэл өгч, тэдэнтэй зөвлөлдөж, газар эзэмшил болон түүнээс үүдсэн үр дагаврын талаар тэд санаа бодлоо илэрхийлэх боломж бүрдүүлэх ёстой. Хэлэлцсэн асуудал, харилцан ярилцсаны үндсэн дээр гарсан зөвшилцлийг баримтжуулж, холбогдох арилжааны банк, МУ-ын ХААДДХК, СЯ-нд хүргүүлнэ.

Газар эзэмшил нь голдуу нөлөөлөлд өртсөн хүн амд асуудал үүсгэдгийг туршлага харуулж байна. Түүнчлэн хүмүүс төслийн талаар уулзалт зөвлөлдөөнд оролцож, шаардлагатай мэдээлэл авч, шийдвэр гаргах үйл явцад оролцох, ухамсартай сонголт хийх боломжоор хангагдсан үед зөрчилтэй асуудал хамгийн бага байдаг нь харагдаж байна. Энэ нь төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрсдэлтэй байдлыг бууруулдаг төдийгүй, мөн газар эзэмшил, нүүлгэн шилжүүлэлтийн улмаас үүсч болох төслийг эсэргүүцэх зөрчилдөөнөөс зайлсхийхэд туслана.

#### **6. Зардал ба төсөв**

Дэд төсөл бүрт газар эзэмшихтэй холбоотой гарах зардал, газар олж авах, нөлөөлөлд өртсөн хүмүүст нөхөн олговор олгох, нөлөөлөлд өртсөн айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, тэднийг шилжин суурьшуулахад гарах зардлуудыг гаргах хангалттай төсөвтэй байлгах тал дээрМУ-ын ХААДДХК, СЯ анхаарч ажиллана. .

#### **7. Монгол Улсын экспортын хөгжлийн төслийн дагуу нүүлгэн шилжүүлэх буюу газар эзэмших хураангуйлсан төлөвлөгөөний тухай**

Энэхүү төслөөс үр ашиг хүртэж буй аливаа аж ахуй нэгж нь газар эзэмшиж байгаа тохиолдолд энэхүү НШБХ-г хэрэгжүүлэхэд дараахь үндсэн элемент бүхий газар эзэмшлийн төлөвлөгөөг боловсруулна:

- а) шилжин суурьшсан хүн амын тооллого судалгаа, эд хөрөнгийн үнэлгээ

Тооллогын судалгааны үндсэн зорилго нь төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг тогтоож тоолох, газрын тооллого хийх, төслийн нөлөөлөлд өртсөн бусад үндсэн эд хөрөнгө, түүний үнэлгээг бий болгох явдал юм. Уламжилж ирсэн удирдагчид болон олон нийтийн холбоодын тусламж дэмжлэг нь дэд-төслүүдэд хүн амын тооллого судалгаа явуулахад маш их ач холбогдолтой юм. Газрыг түрэмгийлж булааж авах эсхүл нөхөн олговор авах луйврын нэхэмжлэлийг хориглохын тулд хүн амын тооллого нь судалгааны үйл явцын эхний өдөр нөхөн олговор болон бусад туслалцаа авах эрхийг тодорхойлж (олон нийтэд мэдэгдэж), түүнийг тасалбар болгох өдрийг тогтооно. Хүн амын тооллогонд нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийг 100% хамруулна. Үүнийг түүвэр судалгааны үндсэн дээр явуулж болохгүй. Энэхүү мэдээлэлийг доорх хүснэгтээр үзүүлж болно:



	Туслах бүтэц				
	Хана, хашаа				
	Бусад				
Бизнесийн бүтэц Нөхөн олговор	Дэлгүүр, хүнсний үйлчилгээний газар				
	Бусад үйлчилгээ				
	Бусад бизнес				

b) нөхөн олговор болон бусад нүүлгэн шилжүүлэхэд үзүүлэх дэмжлэг тусламжийн тодорхойлолт

Ердийн үед нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөнд янз бүрийн төрлийн газар (хөдөө аж ахуйн эдэлбэр, оршин суух, арилжааны, ашиглаагүй болон бусад хэлбрийн газар) болон үндсэн эд хөрөнгийн (жишээлбэл, байр, дэлгүүр эсхүл арилжааны бүтэц, малын хашаа, бусад тусгай бүтэц, хашаа, худаг, усжуулах шугам, бунхан) нөхөн олговрын хувийг тусган оруулна. Тооллогын үед явуулсан санал асуулгын үр дүнтэй хосолсон нөхөн олговрын хув нь нөлөөлөлд өртсөн хувь хүн болон гэр бүл тус бүрт нөхөн олговор олгох хэмжээг тодорхойлох үндэс болно.

c) нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн иргэдтэй бусад алтернатив хувилбарын талаар зөвлөлдөх

Төлөвлөгөө нь тэдний санаа бодол, асуудал дээр тулгуурласан бол төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс нь газар эзэмшил болон бусад холбогдох нөлөөлөлд илүү сайн, хурдан зохицдог гэдгийг туршлага харуулж байна. Газар эзэмших төлөвлөгөө нь нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвшилцсөн зөвшилцөл дээр суурилах бөгөөд зөвлөгөөний үр дүнг төлөвлөгөөнд товч үзүүлнэ.

d) төлөвлөгөө хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх бүтэц зохион байгуулалтын үүрэг хариуцлага ба гомдол барагдуулах журам

Төлөвлөгөө нь цаг хугацаанд нь үр дүнтэй байдлаар явуулах шаардлагатай арга хэмжээг хангахын тулд эрх бүхий хувь хүн болон бүлэг хүмүүсийн хүлээх менежементийн үүрэг хариуцлагыг тогтоож өгнө. Хэрэв нэгээс олон байгууллага эсхүл хуулийн нэг этгээд төлөвлөгөөний хэрэгжилтэнд оролцож байвал байгууллага эсхүл хуулийн этгээдийн хоорондын зохицуулалтыг хангах, тэдний хооронд юмуу дунд байгаа ямар нэгэн зөрчлийг шийдвэрлэх байдлаар арга хэрэгслийг төлөвлөгөөнд бичиж өгнө.

Хэдийгээр харьцангуй бага болон хүндрэлгүй газар эзэмшилтэй төсөл байсан ч гомдол үүсч болно. Зарим тохиолдолд, гомдол нь төлөвлөлтийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй (жишээ нь, нөхөн олговор хангалтгүй юм уу оройтох) холбоотой байж болох юм.

e) Хэрэгжүүлэх хугацааны хуваарь ба төсөв

Нүүлгэн шилжүүлэлтийг үр ашигтай хэрэгжүүлэх нь зохих дэс дараалалтай арга хэмжээг цаг тухайд нь авч явуулахыг шаардна. Ялангуяа, нөхөн олговор болон бусад тусламжийг нөлөөлөлийн сөрөг үр дагавар гарахаас өмнө хүргэх ёстой.

Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд нөхөн олговор болон бусад хэлбрийн бүх тусламжийн төсвийг зардлын төрөл бүрээр хийсэн үнэлгээтэй хамт оруулна. Түүнчлэн төсөвт нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой захиргааны болон бусад зардал орно.



## Хавсралт С – А категорын төслийн байгаль орчны үнэлгээний тайлангийн агуулга

1. А категорын төслийн байгаль орчны үнэлгээний (БОУ) тайлан нь төслийн байгаль орчны ноцтой асуудалд анхаарлаа хандуулдаг. Тайлангийн цар хүрээ, хэр дэлгэрэнгүй байх нь төслийн болзошгүй нөлөөллөөс хамаарна. Банкинд хүргүүлэх тайланг Англи, Франц, Испани хэлний аль нэг дээр, хураангуйг нь Англи хэл дээр бэлтгэнэ.

2. БОУ-ний тайлан дараах зүйлсийг агуулсан байна (дараалал нь өөр байж болно). Үүнд:

(а) *Хураангуй*. Үр дүн, зөвлөмж болгосон үйл ажиллагаануудыг товч тусгана.

(б) *Бодлого, эрх зүй, засаг захиргааны орчин*. БОУ явагдсан бодлого, эрх зүй, засаг захиргааны орчинг авч үзнэ. Хамтран санхүүжүүлэгчтэй бол байгаль орчны шаардлагуудынх нь талаар бичнэ. Тухайн орны олон улсын байгаль орчны холбогдох гэрээнүүдийг тодорхойлно.

(в) *Төслийн тодорхойлолт*. Төсөл болон түүний газар зүйн байршил, экологи, нийгэм, цаг үеийн нөхцлийн талаар товч тодорхойлж бичнэ. Мөн төслийн талбараас гаднах бүтээн байгуулалт (жишээ нь: хоолой татах, зам тавих, цахилгаан станц, усан хангамж, орон сууц, түүхий эд, бүтээгдэхүүний агуулах барих гэх мэт) шаардлагатай эсэхийг тусгана. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, уугуул иргэдийг хөгжүүлэх төлөвлөгөө шаардлагатай эсэхийг бичнэ<sup>2</sup> (доорх (и), (v) эхийг үзнэ үү). Төслийн талбайн болон нөлөөллийн бүсийн газрын зургийг оруулна.

(г) *Суурь мэдээлэл*. Төсөл хэрэгжих газрын хэмжээсийг үнэлж, физик, биологи, нийгэм эдийн засгийн нөхцөл болон төсөл эхлэхээс өмнө таамаглаж байсан өөрчлөлтүүдийн талаар тайлбарлаж бичнэ. Түүнчлэн төсөлтэй шууд холбоогүй боловч төсөл хэрэгжих нутагт хийгдэж байгаа болон хийхээр төлөвлөгдөж буй бүтээн байгуулалтыг анхаарч үзнэ. Мэдээлэл нь төслийн байршил, дизайн сонгох, төслийн ажиллагаа, нөлөөлөл сааруулах арга хэмжээ төлөвлөхөд холбоотой мэдээлэл байвал зохино. Энэ хэсэг мэдээллийн нарийвчлал, найдвартай байдал, эх үүсвэрийг харуулсан байна.

(д) *Байгаль орчны нөлөөлөл*. Төслийн болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг аль болох тоон үзүүлэлтээр урьдчилан тооцоолж үнэлнэ. Нөлөөллийг сааруулах арга хэмжээг мөн сааруулах боломжгүй үлдэгдэл сөрөг нөлөөлөл байгаа бол түүнийг тодорхойлно. Байгаль орчныг сайжруулах боломжийг эрэлхийлнэ. Хэдий хэмжээний, хэр чанартай мэдээлэл байгаа, чухал ямар мэдээлэл дутуу байгаа, таамаглал гаргахад юу тодорхойгүй байна гэдгийг илрүүлэн тооцож, цаашид анхаарал хандуулах шаардлагагүй сэдвийг тодорхойлно.

(е) *Хувилбарын шинжилгээ*.<sup>3</sup> Төсөл хэрэгжүүлэх газар, технологи, дизайн, төслийн ажиллагааны байж болох хувилбарууд болон төсөл хэрэгжихгүй байх хувилбарын байгаль орчны нөлөөллийг системтэйгээр харьцуулан; эдгээр нөлөөллийг сааруулах боломж; тэдгээрт шаардагдах зардал, хөрөнгө; орон нутгийн нөхцөлд таарах эсэх; тэдгээрийн бүтэц зохион байгуулалтын, сургалтын, мониторингийн шаардлагуудыг харьцуулан шинжилж дүгнэнэ. Хувилбар тус бүрийн байгаль орчны нөлөөллийг аль болох тоон хэмжигдэхүүнээр тооцож, боломжтой бол эдийн засгийн өртгийг нь гаргана. Төслийн тодорхой дизайныг сонгох үндэс суурийг томъёолж, зөвлөмж болгож буй ялгарлын хүлцэх түвшин, бохирдлоос сэргийлэх, бууруулах арга хэмжээний үндэслэлийг тайлбарлана.

(ж) *Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)*. Нөлөөллийг сааруулах арга хэмжээ, мониторинг, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах талаар мэдээлэл агуулна. Тоймыг [ҮАБ 4.01 Хавсралт С](#)-гээс үзнэ үү.

(и) *Хавсралтууд*

- (i) БОУ-ний тайлан гаргахад оролцсон хувь хүн, байгууллагуудын жагсаалт.
- (ii) Ашигласан бүтээл — судалгаанд ашиглагдсан хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй бичвэр материал.
- (iii) Агентлаг хоорондын болон бусад зөвлөлдөх хурал, төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, орон нутгийн төрийн бус байгууллагуудын (ТББ) саналыг авах олон нийтийн хэлэлцүүлгийн бүртгэл. Төслийн нөлөөлөлд өртөгч бүлэг болон орон нутгийн ТББ-дын саналыг авахад хэлэлцүүлгээс өөр арга (жишээ нь: судалгаа) хэрэглэгдсэн бол түүнийг бүртгэлд тодруулж бичнэ.
- (iv) Тайлантай холбогдох юмуу тайланд тусгагдсан өгөгдлийг харуулсан хүснэгтүүд.
- (v) Холбогдох тайлангуудын жагсаалт (жишээ нь: албадан нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө).
1. А категорын төслийн БОУ-ний тайлан нь байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ байдаг бөгөөд бусад арга хэрэгслийн зохих элементүүд орсон байдаг. А категорын ямар ч ажиллагааны БОУ-ний тайлан энэхүү хавсралтад заасан бүрэлдэхүүн хэсгүүдтэй байх боловч энэ категорын бүсийн болон салбарын БОУ нь бүрэлдэхүүн хэсгүүдийн дунд арай өөр уялдаа холбоо, онцлолыг шаарддаг. Байгаль орчны салбарын удирдах зөвлөл нь БОУ-ний янз бүрийн хэрэгслийн үндсэн болон бүрэлдэхүүн хэсгийн талаар нарийвчилсан зааварчилгаа өгнө.
  2. [ҮАБ/ББ](#) 4.12 Албадан нүүлгэн шилжүүлэлт, [ҮАБ/ББ](#) 4.10 Уугуул иргэд-ийг үзнэ үү.
  3. Салбарын томоохон бүтээн байгуулалтын сонголтуудын (жишээ нь: ирээдүйн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах өөр өөр арга замууд) байгаль орчны холбогдлыг хямд өртгийн төлөвлөлт юмуу салбарын БОУ-гээр шинжлэх нь зүйтэй. Харин бүс нутгийн томоохон бүтээн байгуулалтын сонголтуудын (жишээ нь: хөдөө нутагт амьжиргааны түвшинг сайжруулах стратегийн хувилбарууд) байгаль орчны холбогдлыг бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөгөө юмуу бүсийн БОУ-гээр авч үзэх нь зүйтэй. Төслийн концепцийн (жишээ нь: гүний дулааны цахилгаан станц эсвэл орон нутгийн эрчим хүчний хэрэглээг хангах зорилготой төсөл гэх мэт) хүрээнд төсөл хэрэгжих газрын, технологийн, төслийн дизайны, төслийн ажиллагааны хувилбарын шинжилгээ хийхэд БОНБУ илүү тохиромжтой байдаг.

#### **Хавсралт D: Байгаль орчны асуудалтай холбоотой Монгол Улсын хуулиуд**

Байгаль орчны хамгаалалтай холбоо бүхий Монгол Улсын гол хууль тогтоомжууд:

- *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБУ-ний тухай хууль, 2012 оны 5-р сард нэмэлт өөрчлөлт оруулсан);*
- *Байгаль орчныг хамгаалах тухай хууль;*
- *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журмыг хэрэгжүүлэх аргачлал;*
- *Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний судалгааны аргачлал, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгааны аргачлал, Төслүүдэд БОНБУ явуулах шалгуурууд, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Мониторингийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх аргачлал.*

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд *Байгаль орчны стратегийн үнэлгээний аргачлал, Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргачлал* зэрэг аргачлалуудыг боловсруулж батласан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулинд байгаль орчны аудитын механизмыг тусган 2012 оны 5-р сарын 17-ноос эхлэн мөрдөж эхлэсэн. Түүний дараагаар Байгаль орчны аудитын аргачлалыг гарган 2013 оны 6-р сараас эхлэн мөрдөж байна. БОНБУ-ний тухай хуулинд хэрэгжүүлэхээр

төлөвлөж байгаа төсөл бүрт байгаль орчны ерөнхий үнэлгээг явуулж, тэдгээрт явуулах шаардлагатай байгаль орчны үнэлгээний төрөл, хамрах хүрээг тодорхойлохыг заасан байна.

Дэд төслийн хэмжээнээс хамааран Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ), түүний орон нутаг дахь салбар байгууллагууд байгаль орчны ерөнхий үнэлгээг хийж, тухайн төсөлд нарийвчилсан үнэлгээ явуулах шаардлагатай эсэхийг тогтоож өгнө. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнүүд (Дэлхийн банкны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй адил) байх бөгөөд төлөвлөж буй байгууламжийг барих зөвшөөрөл олгохоос өмнө тэдгээрийг БОНХЯ-аар хянуулсан байх хэрэгтэй.

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг явуулахдаа олон нийттэй зөвлөлдөх хэлэлцүүлэг явуулах ёстой. Гэхдээ үнэлгээний баримт бичгийн мэдээллийг нийтэд нарийвчлан танилцуулах шаардлагагүй.

## Хавсралт Е: Дэлхийн банкны Хамгааллын асуудлаар баримтлах бодлого

Байгаль орчны үнэлгээ (БОУ) (ҮАБ 4.01) – бусад заалтуудтай уялдан (i) төслийн нөлөөллийг тодорхойлох чанарын ба тоон нарийвчилсан дүн шинжилгээ хийх, (ii) сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, багасгах, нөхөн олгох бодит арга хэмжээг тодорхойлох, (iii) БОУ-ний нэг хэсэг болсон олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээллийг нийтэд мэдээлэх хүргэх ажиллагааг хэрэгжүүлэх, (iv) төслийн дизайн боловсруулах, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үе шатанд авч хэрэгжүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, мониторингийн ажлыг тусгасан БОМТ-тэй байхыг заасан байна.

<http://go.worldbank.org/K7F3DCUDD0>

Байгалийн амьдрах орчин (ҮАБ 4.04) – тус бодлого нь байгалийн амьдрах орчныг хамгаалах, гол чухал байгалийн амьдрах орчныг хувирган өөрчлөх эсвэл доройтуулах үйл ажиллагаа бүхий төслүүдийг дэмжихгүй байхыг шаарддаг. Бодлого нь биологийн олон янз байдал, амьтан ургамлын зүйлүүд, устаж болзошгүй зүйлүүд, тэдгээрийн ховордол, тэдгээрт төслөөс үзүүлэх нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээ, мониторингийн арга хэмжээг тодорхойлох БОУ явуулахыг шаарддаг.

<http://go.worldbank.org/GIFQKJA130>

Соёлын биет нөөц (ОР4.11) – бодлогод хэрэгжүүлэх төслүүдээс соёлын биет нөөцөд нөлөө үзүүлэх, тэдгээрийг сүйтгэх, алдагдуулахаас зайлсхийхийг заасан байна. Соёлын биет нөөцөд тахилгат газрууд, булш хиргэсүүр, археологийн олдвор бүхий газрууд орно. Түүнчлэн бодлого нь (i) Холбогдох материалуудыг судлан төслийн нөлөө бүхий газруудад соёлын биет нөөц байгаа эсэхийг урьдчилан тогтоох, тэдгээрийн байршлыг тогтоох газар дээрх судалгаа шинжилгээ хийх БОУ явуулах, (ii) менежментийн арга хэмжээг тодорхойлсон БОУ/БОМТ гаргах, (ii) барих бүтээн байгуулах болон засах сэргээх ажлын явцад илрүүлэх биет нөөцтэй холбоотой заалтуудыг иргэний ажлын гэрээнд тусгасан байхыг шаарддаг.

<http://go.worldbank.org/UBUBZD7NA0>

Ой (ОР4.36) – бодлого нь ойтой холбоотой үйл ажиллагаа явуулснаар (а) ойн эрүүл мэнд, чанарт нөлөөлөх эсвэл нөлөө үзүүлж болох; (б) иргэд оршин суугчдын эрх, сайн сайхан<sup>3</sup>, бие даасан байдалд нөлөө үзүүлэх төслүүд; (в) нийтийн хэрэгцээний, хувийн, эсвэл нутгийн иргэдийн эзэмшил бүхий байгалийн ба таримал ойн менежмент, хамгаалал, эсвэл ашиглалтанд өөрчлөлт хийхийг хүсч байгаа төслүүдэд хамаарна. Ойн нөхөн сэргээлт эсвэл тарималжуулалт хийгдэх төслүүдэд Дэлхийн банк зээлдэгчийн биологийн олон янз байдал, экосистемийн үүргийг хадгалах, сайжруулах ойн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд туслана.

<http://go.worldbank.org/FGPLNFRFR0>

Уугуул иргэд (ОР4.10) – бодлого нь төсөл хэрэгжих газарт амьдардаг нутгийн уугуул иргэдэд мэдээлэл өгөх чөлөөт хэлэлцүүлэг ярилцлагуудыг урьдчилсан байдлаар зохион байгуулахад бодлогод тусгаснаар оролцохыг Засгийн газраас шаардах бөгөөд төслийн хүрээнд Уугуул иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө/төлөвлөлтийн хөтөлбөр гаргахыг заасан байна

<http://go.worldbank.org/IBZABS9UU0>

Албадан нүүлгэн шилжүүлэлт (ОР4.12) – бодлого нь төслүүдийн үйл ажиллагааны эдийн засаг-нийгмийн шууд нөлөөлөлд чиглэх бөгөөд тухайлбал: (i) орон байрыг нүүлгэх эсвэл алдагдуулах, (ii) өмч хөрөнгө эсвэл өмч хөрөнгөтэй болох боломжийг алдагдуулах, (iii) амьжиргааны болон орлогын эх үүсврийг алдагдуулахад хүргэх (а) албадан газар чөлөөлөлт, (б) тусгай хамгаалалттай газруудыг албан ёсоор байгуулах боломжийг албадан хязгаарласны улмаас газар чөлөөлөлтөнд өртсөн хүмүүсийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг авч үзсэн байна. Бодлого нь эдгээр нөлөөллөөс зайлсхийн төслийн дэд бүтцийн байршлыг тогтоохын зэрэгцээ үзүүлэх нөлөөллийг боломжит хэмжээнд хүртэл бууруулахыг заасан байна. Эдгээрээс зайлсхийх боломжгүй



тохиолдолд (i) нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг, (ii) нүүлгэн шилжүүлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний аль нэг эсвэл аль алиныг гаргах, нөлөөлөлд өртөж байгаа хүмүүстэй уулзалт ярилцлага явуулахыг уг бодлогот заасан байна. Бодлогод тодорхой байршил бүхий дэд бүтцийн төлөө иргэдээс газар хандивлахыг хориглосон байдаг.

<http://go.worldbank.org/ZDIJXP7TQ0>